



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ЯАМ**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО.....	1
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.....	1
ГУРАВ. ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	1-7
3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн	
3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	
3.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт	
ДӨРӨВ. ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ.....	7-8
4.1. Нээлттэй мэдээллийн ил тод байдал	
4.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
ТАВ. ДҮГНЭЛТ.....	8-9
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ.....	9-10



**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

2026 оны 07 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Далайн захиргааны 2026 оны хагас жилийн үйл ажиллагаа, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2026 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

Ерөнхий үнэлгээг Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ын 1 дүгээр хавсралтад заасны дагуу үзүүлэлт бүрийн дүнг 100 хүртэл хувиар илэрхийлэн, үнэлгээний дунджийг харгалзах жинд шилжүүлэх аргачлалаар тооцон дүгнэсэн.

Тус газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайланд тулгуурласны зэрэгцээ бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэлтэй зохих харьцуулалт хийж үнэлж дүгнэсэн болно.

Далайн захиргааны 2026 оны хагас жилийн үйл ажиллагааг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, сайдын тушаалын хэрэгжилт, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн.

ГУРАВ. ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Далайн захиргаа нь 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэхүү гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2026 оны эхний хагас жилийн байдлаар хянан үзэхэд 80.2 хувь буюу “хангалттай” үнэлэгдлээ.



Хүснэгт 1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь			Хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ (%)
				Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй		
				85%-аас дээш	70%-85%	70% хүртэл		
1	Хөлөг онгоц бүртгэх үйл ажиллагаанаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрдүүлнэ.	1	3	1	1	1	-	73.3
2	Далайн болон усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэн боловсруулна.	1	17	12	2	1	2	88.0
3	"Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т тусгагдсан байршлуудад хуурай боомтыг үе шаттай байгуулна.	1	7	5	-	2	-	82.0
4	Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хурал зохион байгуулах, салбарын хүний нөөцийг бэлтгэж, хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.	1	8	4	-	4	-	66.2
5	Монгол Улсын Далайн захиргааны хэвийн үйл ажиллагааг хангана.	1	4	2	-	1	1	66.5
6	Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гарган хэрэглэгчдийг мэдээллээр хангана.	1	3	2	-	-	1	100.0
Нийт/Дундаж		6	42	26	3	9	4	80.2

Тайлбар: Нийт 42 арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан, зорилт тус бүрийн дундаж үнэлгээг арга хэмжээний тоогоор жиллэн тооцоход хэрэгжилтийн дундаж 80.2 хувьтай байна. Энэхүү дүн нь зорилт тус бүрийн бодит хэрэгжилтийг харгалзан гаргасан жиллэсэн үнэлгээ болно.

Далайн захиргааны 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 42 арга хэмжээнээс 62 хувь буюу 26 арга хэмжээ "бүрэн хангалттай", 7 хувь буюу 3 арга хэмжээ "хангалттай", 21 хувь буюу 9 арга хэмжээ "хангалтгүй", 10 хувь буюу 4 арга хэмжээ хэрэгжих хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдлээ.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ

№	Арга хэмжээ	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт	Хувь
---	-------------	-----------------	---------	---------	------



1	Үндэсний аудитын газар болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Хэрэгжилтийн хувь, 100	I-IV улирал	Монгол Улсын Далайн захиргааны даргын 2026 оны 01/121 тоот албан бичгээр Санхүүгийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 29-ний Б/29 дүгээр тушаалаар нягтлан бодогч М.Гантулгад ганцаарчилсан хэлбэрээр сахилгын шийтгэл тооцон ажилласан. Санхүүгийн аудитын зөвлөмжийн хэрэгжилт хагас жилийн байдлаар 16.6% гүйцэтгэлтэй байна. СХШҮДАГ-аас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн 8 зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдөр батлуулан зөвлөмжийн хэрэгжилт 1-р улирлын байдлаар 81,3% үнэлгээгээр үнэлэгдсэн.	50
2	Архангай аймгийн Өгий нуурт усан замын тээврийн "Хяналтын пост"-д завины битүү зогсоолын барилга барина.	I-II улиралд сонгон шалгаруулалт зохион байгуулна.	I-II улирал	Батлагдсан зураг төсвийн дагуу 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр сонгон шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn хуудсанд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Байгууллагын орлогын төлөвлөгөөтэй уялдуулан сонгон шалгаруулалтыг зарлах хугацаа түр хойшлогдоод байна.	0
3	Замын-Үүд байршилд олон улсын хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж гүйцэтгүүлэхтэй холбоотой арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	Төслийн гүйцэтгэл, хувь	I-IV улирал	-Замын-Үүд байршилд олон улсын хуурай боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулж гүйцэтгүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулсан. -Төлөвлөгөөний дагуу 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Замын-Үүд боомтыг "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай" хуулийн хүрээнд хэрэгжүүлэх боломжийн талаар Зөвлөх	50



				үйлчилгээний үнэлгээний хороог 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. -Замын-Үүд сумын нутаг дахь "Бүс нутгийн логистикийн төв"-ийг түшиглэн Замын-Үүд хуурай боомт байгуулах төслийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох төлөвлөлт, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан. -Зөвлөх үйлчилгээний тендерийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр төрийн худалдан авах үйл ажиллагааны цахим системд нийтэлсэн. 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр тендерийг нээсэн. -Үнэлгээний үр дүнд шалгарсан оролцогчтой 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. -Зөвлөх байгууллагаас судалгааны ажлын явцын эхний тайланг 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 01/20 тоот албан бичгээр цахим хэлбэрээр, дундын тайланг 2026 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 01/23 тоот албан бичгээр хэвлэмэл хэлбэрээр тус тус ирүүлсэн.	
4	Хуурай боомтын байршлуудын газрын асуудлыг шийдвэрлэх талаар орон нутгийн удирдлагуудтай хамтарч ажиллана.	Гарсан захирамжийн тоо	II улирал	Чойр хуурай боомтыг байгуулах боломжит 3 байршилтай газар дээр нь танилцаж, хуурай боомт байгуулах 500 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар газрын асуудлыг иргэдийн төлөөлөгчдийн 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн №04 тогтоолоор шийдвэрлүүлж, газрын кадастрын зургийг 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ЗДТГ-аас баталгаажуулсан.	
5	Бусад улсын далайн салбарын эрх бүхий байгууллагуудтай холбоо тогтоож,	Холбоо тогтоосон улс /байгууллага/-ын тоо I-II улиралд 1	I-II улирал	Тайландын Хаант Улстай хамтын ажиллагааны талаар 2026 оны 03 сарын 04-нд цахим уулзалт зохион байгуулсан. Хамтын ажиллагааны үйл	30



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	хамтын ажиллагааг эхлүүлнэ.			ажиллагааны төлөвлөгөө (Action Plan)-г боловсронгуй болгох талаар зөвлөлдөж ондоо багтаан шинэчлэн боловсруулахаар тохиролцсон.	
6	Далайн салбарын байгууллагуудтай хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгүүдийг байгуулна.	Санамж бичгийн тоо, I-IV улиралд 2	I-IV улирал	Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнтэй Монгол орны гол, мөрөн, нуурын экосистемийг хамгаалах, усны чанарт үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, эрдэм шинжилгээ судалгааны хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр санамж бичиг байгуулсан. БНСУ-ын KIOST (Korea Institute of Ocean Science and Technology)-ийн захирал Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр талын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх боломжийн талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Айлчлалын хүрээнд талууд шинжлэх ухааны судалгаа, хүний нөөц бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцсан. Бүгд Найрамдах Панама Улсын Хөлөг онгоц эзэмшигчдийн холбоотой далайн салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулах төслийг боловсруулж Панамын холбоонд хүргүүлсэн.	50
7	Өмнө нь байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.	Санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо I-IV улиралд 5 (Өссөн дүнгээр)	I-IV улирал	БНСУ-ын KIOST (Korea Institute of Ocean Science and Technology)-ийн захирал Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, хоёр талын хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх боломж, чиглэлийн талаар үр дүнтэй уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Айлчлалын хүрээнд талууд шинжлэх ухааны судалгаа, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжуудыг ярилцсан. Түүнчлэн KIOST-д суралцсан төгсөгчидтэй уулзалт зохион байгуулж, тэдний туршлага, оролцоонд	50



				тулгуурлан ирээдүйн төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэх талаар санал солилцсон. Энэхүү айлчлал нь Монгол Улсын Далайн захиргаа болон KIOST байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, мэдлэг, туршлага солилцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.	
8	Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авна.	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо I-IV улиралд 4	I-IV улирал	БНСУ-ын KIOST (Korea Institute of Ocean Science and Technology)-ийн захирал Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэрээ хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийн хүрээнд мэдлэг, туршлага солилцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд ач холбогдол өгч Монгол Улсын Далайн захиргааны 1 ажилтныг тус сургуульд сургах санал ирүүлсэн.	0
9	Байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган тайлагнана.	II улиралд Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулна.	II улирал	Байгууллагын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.	0

3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Тус байгууллагад холбогдох хууль тогтоомжоор үүрэг чиглэл болгосон 3 шийдвэрийн 5 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд хэрэгжилтийн дундаж 90.0 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.

Хүснэгт 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
5	4	1	-	-	-	90.0

3.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт

Тус байгууллагад Зам, тээврийн сайдын 20 тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд хэрэгжилтийн дундаж 90.0 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.



Хүснэгт 4. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
20	17	2	1	-	-	90.0

Хэрэгжээгүй арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Хэрэгжээгүй арга хэмжээ

№	Тушаал	Үүрэг даалгавар	Хэрэгжилт тайлагнасан байдал
1	Журам батлах тухай 2023.11.15 А/296	“Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Далайн захиргаа (Д.Отгонсүрэн), Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий) -т	ЗТХСайдаар батлуулж ХЗДХЯ-нд хууль тогтоомжийн санд бүртгүүлэхээр хүргүүлсэн боловч бүртгэх боломжгүй гэсэн хариу өгч буцаагдсан. Мөн түүнчлэн ЗГХЭГ-аас салбарын захиргааны хэм хэмжээний зохицуулалтыг холбогдох хуульд тусгах замаар тоог цөөлөх чиглэл өгсөн. Үүний дагуу УЗТХуулийг үндэслэн батлагдсан 4 захиргааны хэм хэмжээний актыг хуульд тусгах санал боловсруулагдахад энэхүү журам тусгагдсан болно. Иймээс тус журмыг дахин хууль тогтоомжийн санд бүртгүүлэх шаардлагагүй гэж үзсэн.

ДӨРӨВ. ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Нээлттэй мэдээллийн ил тод байдал

Далайн захиргааны үйл ажиллагааны нээлттэй мэдээллийн ил тод байдалд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 бүлгийн тус газрын үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах шалгуур үзүүлэлт тус бүрээр Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв.

Хяналт-шинжилгээний дүнгээр тус газрын мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн дундаж 77.0 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	70.0
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	77.0
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	88.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	81.0
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	64.0
Дүн		77.0

4.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Далайн захиргаа нь 2026 оны эхний хагас жилд шилэн дансны цахим нэгдсэн системд 89 мэдээлэл байршуулахаас 89 мэдээллийг оруулсан байна. Байршуулсан мэдээллийг хугацаанд нь оруулсан эсэхийг хянаж үзэхэд 88 мэдээллийг хугацаанд нь, 1



мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, шилэн дансны хөтлөлтийн хэрэгжилт 99.0 хувьтай дүгнэгдлээ.

Хүснэгт 7. Шилэн дансны хөтлөлтийн ерөнхий мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл	Байршуулбал зохих мэдээлэл	Байршуулсан мэдээллийн тоо		Биелэлт (хувь)
			Хугацаанд нь	Хугацаа хоцроосон	
1	Төсөв/гүйцэтгэл	26	26	0	100
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	20	20	0	100
3	Бусад	43	42	1	99.0
Нийт		89	88	1	99.0

Дээрх хүснэгтээс үзэхэд тус газар нь шилэн дансны цахим системд 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хугацаа хоцроон байршуулсан мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 8. Хугацаа хоцроосон мэдээлэл

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Мэдээлэл оруулсан огноо
1	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	2026.07.01	2026.07.03

4.3. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Зам, тээврийн яамнаас Далайн захиргааны 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн 8 зөвлөмжийн хэрэгжилт 2026 оны хагас жилийн байдлаар 81.3 хувьтай байна.

Хүснэгт 9. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо						Үнэлгээ
		Нийт	Үүнээс					
			Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
1	Зам, тээврийн яам	8	6	1	1	-	-	81.3

4.4. Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Далайн захиргаа нь 2026 оны эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гаргаагүй, төлөвлөлт, боловсруулалтын шатанд байгаа талаар танилцуулсан.

ТАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Далайн захиргааны 2026 оны хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус байгууллагын ерөнхий үнэлгээ 81.0 хувьтай байна.

Хүснэгт 10. Ерөнхий үнэлгээ

Үзүүлэлт		Жин	Хэрэгжилт (хувь)
1	2	3	4



Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	20	80.2
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	20	90.0
	Сайдын тушаалын хэрэгжилт	10	90.0
Чадамжийн үнэлгээ	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	10	77.0
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10	99.0
	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	15	81.3
	Эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	5	0
Ерөнхий дүн (жинлэсэн дундаж)		90	81.0

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт “хангалтгүй” гэж дүгнэгдсэн нь төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй, хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, бусад байгууллагаас зөвшөөрөл олгох, хамтран хэрэгжүүлэх үйл явц удаашралтай зэрэг шалтгаантай холбоотой гэж дүгнэлээ.

Нээлттэй мэдээллийн ил тод байдалд хийсэн хяналт-шинжилгээгээр тус газрын мэдээллийн хүртээмжтэй байдал дутмаг, мэдээллийн самбарт байршуулсан байдал болон бусад мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх үйл ажиллагаа хангалтгүй зэрэг нөхцөл байдал тогтоогдлоо.

Шилэн дансны цахим нэгдсэн системд 89 мэдээлэл байршуулахаас 88 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг 2 хоног хугацаа хоцроон байршуулсан байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Далайн захиргааны 2026 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг бүрэн хангуулах;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг нотлох баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж ирүүлэх;
3. Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах;
4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үзүүлэлтийг тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох баримтыг хавсаргах, вэб сайт дээрх нээлттэй мэдээллийг тогтмол шинэчилж, дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж, холбоо барих албан тушаалтны мэдээллийг бүрэн байршуулж байх;
5. “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” зэрэг баримт бичгүүдэд үндэслэн байгууллагын эрсдэлийн төлөвлөгөөг яаралтай боловсруулж, заалт бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг хангах;



6. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж, биелэлт, үр дүнг сайжруулах;

ТАНИЛЦСАН:
САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.БАЯРМАГНАЙ

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА

М.ӨЛЗИЙ

ХЯНАСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Х.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭНИЙН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ӨЛЗИЙДЭМБЭРЭЛ

